



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/326

Булган сум

Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны IV/25 хуралдааны дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 05 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан томилолтоор ажиллах төлөөлөгчдийн нэрсийг 1 дүгээр, албан томилолтод шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 10,837,800 (арван сая найман зуун гучин долоон мянга найман зуу) төгрөгийн зардлаас 7,980,200 (долоон сая есөн зуун наян мянга хоёр зуу) төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс, 2,857,600 (хоёр сая найман зуун тавин долоон мянга зургаан зуу) төгрөгийг төсөл, хөтөлбөрийн зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 16-ны/ний өдрийн
А/326 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД АЛБАН
ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ТӨЛӨӨЛӨГЧИД

Д/д	Овог нэр	Албан тушаал
1	2	3
1	Очирпүрэв Ундрах	Аймгийн Засаг даргын орлогч
2	Дашзэвэг Эрдэнэбилэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
3	Цогтсайхан Энх-Амгалан	Нийгмийн даатгалын газрын дарга
4	Ахлаан Зина	Солонгос хэлний орчуулагч

Аймгийн Засаг даргын 20.25 оны
05 дугаар сарын 16-ны/ний өдрийн
А/326 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Гадаад албан томилолтод шаардагдах зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Нэгжийн үнэ /төгрөг/	Дүн /төгрөг/
1	2	3	4
1	Тийзийн үнэ /УБ-Дэгү-УБ, 2 хүн/	1,132,500	2,265,000
2	Томилот /3 хүн, 4 өдөр/	714,400 /200\$*3,572 төг/	8,572,800
	Нийт дүн		10,837,800